



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2021 оны 02 сарын 18 өдөр

Дугаар 8/22

Мандалговь

Г Ажлын хэсэг байгуулах тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.6 дахь заалт, аймгийн Засаг даргын Тамгын газрын “Байгууллагын хөдөлмөрийн дотоод журам батлах тухай” 2020 оны А/120 дугаар тушаалын 3.14 дэх хэсгийн 2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн “Хүний нөөцийг хөгжүүлэх хөтөлбөр”-ийг боловсруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч: Л.Доржбат (Аймгийн ЗДТГ-ын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Гишүүд: С.Цэнгэлмаа (Хууль эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн)

Э.Одончимэг (Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн ахлах мэргэжилтэн)

Ж.Батбилэг (Хүнс, хөдөө аж ахуйн газрын мал үржлийн албаны дарга)

Р.Мөнхбаясгалан (Эрүүл мэндийн газрын хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтэн)

О.Мөнхзул (Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн)

Д.Алтантогос (Говийн хөгжил наран ТББ-ын тэргүүн)

О.Эрдэнэтөгс (Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгч)

Нарийн бичгийн дарга: С.Хулан (Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга)

2. Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа 2050”, “Монгол улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” болон бусад төрийн бодлого, хууль тогтоомжуудтай уялдуулан, төрийн болон төрийн бус байгууллага, иргэд, олон нийтийн саналыг тусган аймгийн “Хүний нөөцийг хөгжүүлэх хөтөлбөр”-ийг боловсруулан 2021 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн дотор аймгийн Засаг даргын Зөвлөлийн хуралд танилцуулж батлуулахыг ажлын хэсэг (Л.Доржбат)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ И.ДОРЖБАТ Л.ДОРЖБАТ

486210038